



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 26 өдөр

Дугаар A/556

Булган сум

Үнэлгээний хороо өөрчлөн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/303 дугаар захирамжаар байгуулагдсан Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Биеийн тамирын заалны барилга (Могод сум)”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Б.Будцэцэг нь эрүүл мэндийн шалтгаанаар түр чөлөөтэй байгаа тул үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн А.Гэрэлийг томилсугай.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Д.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д. ПҮРЭВ-ОЧИР



6325010769